

4

БАНКНААС ГАДУУРХИ МӨНГӨНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

А.Цэрэнтоого

Банк ба мөнгөний харилцан холбоог хүний биеийн амин эрхтэн болох зүрх, түүгээр урсан өнгөрөх цустай адилтган зүйрлэдэг. Үнэхээр мөнгө нь түүнд нийгэмд нэвтэрч орж чаддаггүй газар гэж байдаггүйгээрээ цустай адил юм. Үүнтэй адил товар мөнгөний харилцаа хаана бол хаана нэвтэрч чаддаг. Харин төв банк нь бэлэн мөнгөний зарим хэсгийг нөөцлөн барьснаар түүгээрээ эдийн засагт тархсан бэлэн мөнгөний хэмжээнд нөлөөлж, түүнийг хянаж чаддаг.

Хүснэгт 1

Он	Нийт мөнгө		Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө		Нийт мөнгөнд, гүйлгээнд байгаа мөнгөний эзлэх хувь хэмжээ
	сая.төг	өсөлтийн хурд	сая.төг	өсөлтийн хурд	
1990	5633.11	-	742.7	-	13.2%
1991	9914.8	76.0%	2003.0	169.7%	20.2%
1992	13052.3	31.6%	2896.4	44.6%	22.2%
1993	42764.2	227.6%	10786.1	272.4%	25.2%
1994	76777.0	79.5%	21804.8	102.2%	28.4%
1995	102044.6	32.9%	29755.7	36.5%	29.2%
1996	128395.3	25.8%	46095.8	54.9%	35.9%
1997	170065.5	32.4%	56816.5	23.3%	33.4%
1998	167249.6	-1.7%	61754.2	8.7%	36.9%
1999	220167.0	31.6%	91567.5	48.3%	41.6%
2000	258842.6	17.5%	107394.5	17.2%	41.5%
2001	331064.3	27.9%	119205.8	11.0%	36.0%
2002	470125.6	42.0%	134642.8	-1.5%	28.6%

Мөн хугацаанд зөвхөн гүйлгээнд байгаа мөнгөний эзлэх хувь хэмжээ өссөн төдийгүй, нийт мөнгөний өсөлтийн хурдаас гүйлгээнд байгаа мөнгөний өсөлтийн хурд ямагт түрүүлж байгаа нь мөнгөний өсөлт өргөжилтөд нөлөөлөх гол хүчин зүйл нь гүйлгээнд бэлэн мөнгө гаргах явдал байжээ.

2000 оноос харин гүйлгээн дэх бэлэн мөнгөний өсөлтийн хурд саарч, улмаар буурах хандлагатай байна.

1995-1996 оны үед Монгол банк мөнгөний нийлүүлэлт M_2 -ын өсөлтийн түвшин болон инфляцийн түвшингийн хоорондын хамаарал хүчтэй байгааг анзаарсан. (өөрөөр хэлбэл өсөлт бууралтын хандлага нь ижил) цаг хугацааны хувьд ч ойролцоо, хоорондоо 1 сарын зайтай илэрч байгааг ажиглан, инфляцийн зорилтот түвшинг барихын тулд M_2 -ын өсөлтийг түүнтэй ойролцоо хэмжээнд барихыг эрмэлзэх болсон. Үнэхээр ч тэр үед M_2 -мөнгөний бодлогын гол чиглүүлэгч байсан. Гэвч мөнгөний үржүүлэгч өөрчлөгдөхөд тэр хамаарал алдагдаж байсан учраас 97 оноос нөөц мөнгөөр дамжуулан инфляцийг зохицуулах болсон.

Нөөц мөнгө нь банкнаас гадуурх мөнгө болон банкуудын нөөц хоёрын нийлбэрээс тогтдог. Зөвхөн нөөцөөр мөнгөний нийлүүлэлтийг удирдах нь хангалтгүй байсан учраас мөнгөний бодлогоо төсвийн бодлого, төлбөрийн тэнцэл, эдийн засгийн улирлын чанартай идэвхжил, сулралтай холбон зохицуулж ажилласнаар 1998 онд инфляцийн түвшинг 6% болтол бууруулж улмаар дараагийн жилүүдэд буурах боломж бий болов. Нөөц мөнгөний хэмжээг төв банкнаас өдөр бүр хянах боломжтой тул одоо ч гэсэн мөнгөний нийлүүлэлтийг зохицуулах гол хэрэгсэл болсоор байна. Банкнаас гадуурх мөнгө нь нөөцийн төлөвлөлтийн цаашилбал мөнгөний бодлогод таамаглахад хэцүү, тохиолдлын гэмээр өөрчлөлтөөрөө нөлөөлж мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийг зорьж буй үр дүнгээс нь хазайлган, үр нөлөөг нь багасгадаг. Ийм учраас банкнаас гадуурх бэлэн мөнгөний шинж чанар, түүний хөдлөл хөдөлгөөнийг судлах бодит шаардлага бий болсон юм.

Үүнийг илүү тодорхой авч үзье. Нийт мөнгө ба нөөц мөнгөний хамаарлыг илтгэгч нөөц мөнгөний үржүүлэгч хэмээх үзүүлэлт байдаг. Энэ үзүүлэлтэд банкнаас гадуурх мөнгө, татан төвлөрүүлсэн хөрөнгийн харьцаа гол нөлөө үзүүлдэг. Өөрөөр хэлбэл, банкнаас гадуурх мөнгө хэт их өссөн тохиолдолд нөөц мөнгөний үржүүлэгч багасч тэр хэмжээгээр нөөц мөнгөний нийт мөнгөнд нөлөөлөх чадвар нь буурдаг. Үүнийг дагаад мөнгө зээлийн бодлогын шууд бус арга хэрэгслүүдийн ч үр нөлөө буурна. Нөгөө талаар банкнаас гадуурх мөнгө ихэссэнээр хөрөнгө оруулалтанд зориулагдах ёстой байсан мөнгө гараас гар дамжин үргүй эргэлт хийх нь эдийн засагт муугаар нөлөөлж байна. Мөн мөнгөний агрегатуудаас инфляцад хамгийн хүчтэй нөлөөлж байдаг нь банкнаас гадуурх мөнгө юм. Учир нь банкнаас гадуурх мөнгөний огцом өсөлт нь инфляцийг богино хугацаанд хөөрөгдөх чадалтай.

Энэ бүхнээс үзэхэд банкнаас гадуурх бэлэн мөнгөнд анхаарлаа хандуулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Он	Гүйлгээнд байгаа мөнгө		Банкнаас гадуурхи		Гүйлгээнд байгаа мөнгөнд, банкнаас гадуурхи мөнгөний эзлэх хувь
	сая.төг	өсөлтийн хурд	сая.төг	өсөлтийн хурд	
1990	742.7	-	737.0	-	99.2%
1991	2003.0	169.7%	1694.3	129.8%	84.5%
1992	2896.4	44.6%	1839.2	8.6%	63.4%
1993	10786.1	272.4%	8750.6	375.8%	81.1%
1994	21804.8	102.2%	18767.2	114.5%	86.1%
1995	29755.7	36.5%	25591.2	36.4%	86.0%
1996	46095.8	54.9%	41704.4	63.0%	90.4%
1997	56816.5	23.3%	49768.3	19.3%	87.6%
1998	61754.2	8.7%	56445.8	13.4%	91.4%
1999	91567.5	48.3%	87281.3	54.6%	95.3%
2000	107394.5	17.2%	100933.4	15.6%	94.0%
2001	119205.8	11.0%	109160.7	8.2%	91.6%
2002	134642.8	12.9%	120783.6	10.6%	89.7%

Судалгаанаас харахад 2000 он хүртэл гүйлгээнд байгаа мөнгөний өсөлтийн хурдаас, банкнаас гадуурх мөнгөний өсөлтийн хурд ерөнхийдөө түрүүлэх хандлагатай байгаа нь ажиглагдаж байна.

Харин 2000 оноос банкнаас гадуурх мөнгөний өсөлт саарч эхэлсэн байна.

Гэхдээ гүйлгээнд байгаа мөнгөнд банкнаас гадуурх мөнгөний эзлэх хувийн жин сүүлийн жилийн дунджаар 90 гаруй хувийг эзэлж байна. Нийт гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний 10 хүрэхгүй хувь нь банкаар дамжин гүйгдэж байгаа аж ахуйн нэгж, хүмүүсийн мөнгө юм. Ийм нөхцөлд инфляцийг тогтвортой байлгах мөнгөний бодлогыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байх нь ойлгомжтой юм.

Банкнаас гадуурх мөнгөний өсөлтийн шалтгаан, түүнийг бууруулах арга зам

Банкнаас гадуурх бэлэн мөнгө их байгаа нь дотоодын нийт бүтээгдэхүүний нэрлэсэн үнийн өсөлт, мөнгөний эмисс, инфляцийн түвшин гэх зэрэг хүчин зүйлстэй ихээхэн уялдаж байна. Түүнчлэн бэлэн бус төлбөрийн хэрэгсэл хөгжөөгүй, татвараас зайлсхийх үүднээс бэлэн мөнгөнийг гар дээрээ байлгаж, тооцоогоо хийх сонирхол их байгаа зэрэг нь үүнд дам нөлөөлж байна.

Хүмүүс бэлэн мөнгөнийг гар дээрээ барих сонирхол өсч байгаа нь дараах хэдэн шалтгаантай. Үүнд:

1. Бэлэн мөнгөөр худалдаа арилжаа хийх нь орлогоо нууж, татвараас зайлсхийх боломжтой байдаг. Жишээ нь гэвэл манай улс жилд татвараар авах ёстой 100 тэрбум төгрөгийг авч чаддаггүй гэдэг.
2. Сүүлийн жилүүдэд хадгаламжийн хүүгийн дундаж буурч, төгрөгийн хадгаламжийн өсөлт нь хугацаат хадгаламж болон валютын хадгаламжийн дэргэд маш бага гарах болсон.
3. МУ-ын ДНБ-ний 30 хувьтай тэнцэх хэмжээний сүүдрийн эдийн засгийн хүрээ хязгаар жил ирэх тусам улам тэлж, үүнийг даган түүний бэлэн мөнгөний эргэлт нь нэмэгдсээр байгаатай холбоотой юм.

Монгол банкны мэдээллээс харж байхад манай орны жил бүрийн 4, 5-р болон 12-р сард банкнаас гадуурхи мөнгө маш огцом өсөх явдал давтагддаг байна. Сарын өсөлт нь 14-15%-д хүрдэг байна. Үүний учир нь энэ үед ноолуур цуглуулах ажил орон даяар өрнөж, ноолуурын ханш ч өсч, үүнийг даган бэлэн мөнгө асар их шаардлагатай болдог. Албан бус мэдээгээр энэ үед банкнаас гадуурхи мөнгөний 40 хувь нь түүхий эдийн зах дээр эргэлдэж байдаг гэсэн тоо байдаг.

Монгол улс жилдээ 3300 тн ноолуур самнаж авдаг. Энэ ноолуурыг хөдөө явж цуглуулахад дор хаяж 100 тэрбум төгрөг шаардлагатай. Дээр нь Монгол орны эдийн засгийн улирлын чанартай идэвхжил, сэргэлт өрнөж газар тариалан, барилга, алт олборлолт гээд чамгүй хөрөнгө санхүүжилт 4, 5-р сард хэрэгтэй болдог.

Харин жил бүрийн сүүлчээр буюу 12-р сард банкнаас гадуурхи мөнгө бас нэлээд хувиар өсдөг нь энэ үед санхүүгийн жил дуусгавар болж, засгийн газар цалин тэтгэвэрийнхээ дутууг олгож банкны системээс их хэмжээний мөнгө гарч оддогтой холбоотой. Харин сарын дараа буюу дараа жилийн 1-р сард нь бэлэн мөнгөний эрэлт огцом буурч, банкнаас гадуурхи мөнгө өмнөх сараасаа дунджаар 12 хувиар буурдаг байна.

Бэлэн мөнгө-татвараас зугтах түгээмэл арга: Татвар төлөгчид татвараас зугтдаг түгээмэл арга нь бэлэн мөнгөөр арилжаа хийж, борлуулалтын орлогоо нуух явдал байдаг. Ихэнх тохиолдолд тооцоогоорх авлага гардаггүй орлогын падаан, төлбөрийн баримт үйлддэггүй. Түүнчлэн тодорхойгүй олон тооны харилцагчтай тохиолдлын чанартай арилжаа хийгддэг учраас татварын хэмжээг тогтоох аргагүйд хүрдэг байна. Ийнхүү борлуулалттай холбоотой анхан шатны бүртгэл хөтлөгддөггүй учраас татвар оногдуулалтанд тодорхойгүй байдал, хүндрэлүүд гардаг учир татварыг байх ёстойгоос нь багаар оногдуулдаг. Харин үүнийг бизнес эрхлэгчид овжноор ашиглан аль болох бэлэн мөнгөөр арилжаа хийхийг эрмэлзэх болсон.

Татварын байцаагчид хяналт шалгалт хийхдээ юун түрүүнд бизнес эрхлэгчийн бэл бэнчин хэр нэмэгдсэнийг, ялангуяа нэрийн хадгаламж нь хэр зэрэг өссөнийг сонирхдог учраас эдгээр хүмүүс татвараас нуусан орлогоо шүүгээндээ хурааж, эргүүлэн бэлнээр зарцуулдаг байна. Банкны систем рүү орох мөнгөн урсгалын тодорхой хэсэг нь ийнхүү сүүдрийн эдийн засагт эргэлдэн үлддэг байна.

Банкнаас гадуурхи бэлэн мөнгийг багасгах арга замууд:

- ◆ чек, зээлийн картын хэрэглээг дэлгэрүүлэх
- ◆ аж ахуйн нэгжүүдийг орлогоо байнкинд тушаадаг болгох
- ◆ орлого ашиг өндөртэй ХК-иуд нэмж хувьцаа гарган борлуулах.

Зээлийн картын хэрэглээг дэлгэрүүлэх: Бэлэн бус тооцооны дэвшилтэт хэлбэрүүдийг банкаар дамжуулан өргөн хэрэглэх, хүн ам өрх гэрт банкны үйлчилгээг ойртуулах цаг аль хэдийн болжээ. Банкны системийн хэмжээгээр бий болсон хямрал арилаагүй байгаагийн улмаас орчин үеийн үйлчилгээний хэлбэр болох лизинг, факторинг, төлбөр тооцооны шинэлэг хэлбэр болох карт, чек, вексель болон бусад үйлчилгээ хоцрогдон, хүмүүсийн гар дээрхи бэлэн мөнгөний үйлчилгээг хөхүүлэн дэмжихэд хүрч байна.

Бусад орнуудад төлбөр тооцооны 85-90% нь бэлэн бус шилжүүлэг, вексель, карт, чек гэх мэт хэлбэрээр, 10-15% нь бэлэн мөнгөөр (тэмдэгтээр) гүйгддэг бол манайд үүний эсрэг байдал үүсчихээд байгаа юм. Бэлэн мөнгөний хэмжээг багасгах зорилгоор төв банкнаас бэлэн бус төлбөрийн хэрэгсэл болох векселийн тооцоог нэвтрүүлэх боломж, орчин нөхцлийг бүрдүүлж банкуудаас гарч буй чек, соронзон картын үйлчилгээг дэмжиж байгаа боловч банкнаас гадуурхи мөнгөний хэмжээг дорвитой бууруулж чадахгүй байгаа юм. Чек, зээлийн карт, векселүүд нь одоо ломбардуудын явуулах жижиг зээлийг орлох чадвартай. Ингэснээр ломбардуудын шударга бус мөнгө хүүлэх ажиллагаа, хулгайн замын үнэт эдлэлүүдийг угаадаг бохир бизнесийг зах зээлээс нь шахах бололцоо гарах юм. Мөн ломбардуудтай зэрэгцэн бий болсон валют солих, данснаас бэлэн мөнгө гаргах гэх мэт завсрын үйлчилгээ эрхэлдэг байгууллагуудын тоо ч цөөрөх болно. Төлбөрийн карт нь хэдийгээр зээлэх мөнгөний хэмжээ бага боловч нийт дүнгээрээ тэдгээр нь маш их мөнгийг банкинд татдагийг бусад орнуудын түүх баталж байна. Ер нь арилжааны банкууд олгох зээлийнхээ хэмжээг багасгаж жижиглэх нь зээлийн эрсдэлийг бууруулдаг талтай.

Одоогоор арилжааны хэд хэдэн банкууд VISA, Master card, American express зэрэг олон улсад өргөн ашиглагддаг зээлийн картыг манайд нэвтрүүлэх талаар чармайлт тавьж байна. Ер нь дебет, кредит картыг нэвтрүүлэх ажил манайд эхэн шатандаа л явж байгаа бөгөөд энэ үедээ тоног төхөөрөмж оруулж ирэх, суурилуулах гэх мэт хөрөнгө оруулалт, зардал их шаардлагатай байдаг. Харин томоохон аж ахуйн нэгжүүд өөрийн үйлчлүүлэгчдээ төлбөр тооцоог хөнгөн шуурхай, гүйлгээг төвөг чирэгдэл багатай явуулахын тулд өөрсдийн төлбөрийн карт нэвтрүүлэх болсон нь санаачлагатай, сайшаалтай явдал юм. Тэдний зүгээс ийнхүү зүтгэл гаргаж байгаа үед нь банкууд үүнийг дэмжээд эрсдэлээс айхгүйгээр хамтран ажиллах хэрэгтэй байгаа юм.

Пластик картыг олны хэрэглээ болгоход эхэн үедээ урамшуулалт үзүүлж, ашигтай санал тавихын зэрэгцээ энэ картыг эзэмшснээр олох давуу талыг хүмүүст ойлгуулах нь зүйтэй юм. Үүнд:

- ◆ Зээлийн карт эзэмших нь тухайн хүний нэр хүндийн асуудал
- ◆ Бэлэн мөнгийг бодвол хэрэглэхэд төвөг багатай, цаг хэмнэнэ

- ◆ Риск буурна.
- ◆ Валют солиход санаа зовох хэрэггүй болно.

Харин зээлийн картны үйл ажиллагаа эрхэлсэн банкны хувьд үйлчилгээний хариуд орлого олохоос гадна татан төвлөрүүлсэн хөрөнгө нэмэгдэж, дэлхий нийтийн хандлагыг даган хөл нийлүүлэн алхаснаар банкны өрсөлдөх чадвар дээшлэх юм.

Аж ахуйн нэгжүүдээс бэлэн мөнгийг банкинд төвлөрүүлэх: Банкнаас гадуурхи бэлэн мөнгийг бууруулахад арилжааны банкууд ихээхэн үүрэгтэй. Арилжааны банкууд өндөр орлоготой аж ахуйн нэгжүүдийн орлогыг банкиндаа төвлөрүүлэн хураах эрмэлзэл (сонирхол)-той болбол банкны хүрээнд орох бэлэн мөнгөний урсгал нэмэгдэх юм. Үүнд төв банкны хөшүүрэг хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, арилжааны банкуудад бэлэн мөнгө татахыг нь дэмжсэн төв банкин дахьхарилцахад нь төлдөг хүүг нь өсгөх эсвэл Төв банкны үнэт цаасыг мөнгөжүүлэн, хөрвөх чадварыг нь дээшлүүлэн арилжааны банкуудын худалдан авах сонирхлыг нь нэмэгдүүлж чанартай актив болгох талаар бодлого боловсруулах хэрэгтэй юм.

Худалдаа үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийн (хүнсний болон барааны бөөний төв, томхон дэлгүүр, бар цэнгээний газрууд) ихэнх нь борлуулалтаа бэлэн мөнгөөр хийдэг. Иймд тэднийг мөнгөөр орсон орлогоо кассын машинаар бүртгэдэг болгох зохицуулалт хэрэгтэй байна. Жишээ нь: ийм аж ахуйн нэгжүүдийг ямар нэгэн зөвшөөрөл (патент, лиценз) авахад нь төвөг чирэгдэл учруулахгүйгээр нэг дор бүгдийг нь шийдээд өгчихдөг болох эсвэл тэдэнд хууль тогтоомжоор хөнгөлөлт үзүүлэх дарамт шахалтыг арилгах нь зүйтэй. Ер нь аж ахуйн нэгжүүд кассын машин хэрэглэдэг болсноор татвараас зугтах боломж ихээхэн багасдаг учраас татварын алба ч үүнд оролцож хамтран ажиллах шаардлагатай. Харин арилжааны банкууд эдгээр аж ахуйн нэгжүүдийг орлогоо банкинд тушаадаг болгоход нь анхаарч, үүнд үйл ажиллагаагаа чиглүүлэх ёстой. Ингэснээр банкны системд бэлэн мөнгийг татан төвлөрүүлж чадах юм.

Ер нь карт, чекээр үйлчилдэг болон кассын машинтай аж ахуйн нэгжүүдийг нэг бүлэг болгон онцолж, тэдэнд анхаарал тавин, хөнгөлөлт эдлүүлж, дарамт шахалтыг нь бууруулснаар ийм аж ахуйн нэгжүүдийн тоо нэмэгдэх юм.

Үйл ажиллагаа нь амжилттай яваа ХК-иуд хувьцаа гаргах: Банкнаас гадуурхи мөнгийг хөрөнгө оруулалтанд ашиглах нэгэн арга бол одоо үйл ажиллагаа нь амжилттай яваа, ашиг орлого сайтай компаниуд хувьцаа гарган худалдах явдал юм. Өөрөөр хэлбэл, сул чөлөөтэй мөнгөн хөрөнгө орлогыг максимум байлгах үйлдвэрлэлийн салбар луу чиглэж үндэсний эдийн засгийн үр ашигтай бүтцийг бий болгоно. Өнөөдөр хувьцааны бирж дээр өндөр үнээр идэвхтэй арилжаалагдаж байгаа компаниуд нэмж хувьцаа гаргавал техник технологио шинэчилж, үйлдвэрлэлээ өргөжүүлэх боломжтой болно.

Банкнаас гадуурхи бэлэн мөнгийг бууруулахад зөвхөн банк анхаарч, арга хэмжээ авч хэрэгжүүлсэнээр шийдвэрлэгдэх асуудал биш юм. Энд банк, санхүү, татвар болон төр засгийн байгууллагуудын нэгдмэл бодлого, зохицуулалт шаардлагатай байна.